

Христийн гэрэл

Христийн гэрлийг тодорхойлох

Сургаал ба Гэрээ 88:12–13-ыг уншаад, Христийн гэрлийг хэрхэн дүрсэлснийг олж мэд.

Христийн гэрлийн дараах тодорхойлолтыг унш.

“[Христийн гэрэл бол] Христээр дамжин Бурханаас ирж мөн бүх зүйлд амьдрал хийгээд гэрлийг өгдөг бурханлаг эрч хүч буюу нөлөө. Энэ бол тэнгэр, газар дээрх бүх зүйл түүгээр зохицуулагддаг хууль юм (С ба Г 88:6–13). Энэ нь түүнчлэн сайн мэдээний үнэнийг ойлгоход, тэрчлэн аврал руу хөтөлдөг сайн мэдээний тэрхүү зам дээр гарахад хүмүүст тусалдаг.” (Судруудын удирдамж, “Гэрэл, Христийн гэрэл,” scriptures.ChurchofJesusChrist.org)

- Та нар Христийн гэрлийн талаарх ойлголтоо хэрхэн дүгнэх вэ?
- Христийн гэрэл та нарт хувь хүний чинь хувьд хэрхэн нөлөөлсөн гэж бодож байна вэ?

Христийн гэрэл бол бидний ухамсар юм

Христийн гэрлийн нэг илрэл бол бидний ухамсар. Ухамсрын талаарх ойлголтоо Хүүхдийн хэсгийн хүүхдэд ойлгогдохоор тодорхойлон бич.

Дараах тодорхойлолтыг уншаад, өөрийн тодорхойлолтод юу нэмж болохыг хар.

“[Ухамсар нь] бүх хүмүүст Христийн гэрлээс ирдэг зөв ба буруугийн дотоод мэдрэмж юм (Морон. 7:16). Христийн гэрэл хүн бүхэнд өгөгдсөн учраас бид төрөхдөө зөв бурууг ялгах төрөлхийн чадвартай байдаг (С ба Г 84:46). Энэ чадварыг ухамсар гэдэг. Үүнийг эзэмшсэнээр бид хариуцлагатай бие хүмүүс болдог. Бусад чадварын нэгэн адил бидний ухамсар нүглээс болон буруу ашигласнаас болж мөхөж болно.” (Судруудын удирдамж, “Ухамсар,” scriptures.ChurchofJesusChrist.org)

Сургаал ба Гэрээ 84:45–46 ба Моронай 7:16-г уншаад, Христийн гэрэл бидний ухамсрын үүргийг хэрхэн гүйцэтгэдгийг дүрсэлсэн үг, хэллэгийг хайж ол. Хоёр эшлэлийг холбоотой болгон тэмдэглэх талаар бодож үз.

- Эдгээр шүлэгт ухамсар гэж юу болохыг ойлгоход туслах ямар үг хэллэг байна вэ?
- Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр яагаад та нарт ухамсар суулгасан гэж бодож байна вэ?
- Ухамсраа дагах эсвэл үл тоомсорлох нь та нарын сонголт болон мөнхийн аянд хэрхэн нөлөөлөх вэ?